МОНГОЛ УЛСЫН
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО

Засгийн газрын XI байр, Ж.Самбуугийн гудамж 11,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15141
Утас: 26 09 75, Цахим шуудан: gecm@gec.gov.mn,
Цахим хуудас: www.gec.gov.mn

2026.11.06 № 1/553
танай 2026.11.03 -ны № УИХ-03/12335 т

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН Д.ҮҮРИЙНТУЯА ТАНАА

Хариу хүргүүлэх тухай

Танаас 2026 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр тус Хороонд ирүүлсэн Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд санал авах УИХ-03/12335 дугаар албан бичиг болон хуулийн төсөлтэй танилцаад дараах хариуг хүргүүлж байна.

Шийдвэр гаргах түвшинд жендерийн тэгш байдал, тэгш оролцоог хангах зорилгоор Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд 2023 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр уг хуулийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсгийг “Нам, эвслээс нэр дэвшүүлэхэд 2024 оны ээлжит сонгуулиар нийт нэр дэвшигчийн 30-аас доошгүй хувь нь, 2028 оны ээлжит сонгуулиар 40-өөс доошгүй хувь нь аль нэг хүйсийнх байна.” гэж өөрчлөн найруулсан, мөн уг зохицуулалтын хэрэгжилтийг бүрэн хангуулах зорилгоор хуулийн 33 дугаар зүйлд “энэ хуулийн 30.1, 30.2, 30.4, 30.6-д заасан нэр дэвшүүлэх ажиллагааны журам зөрчсөн бол нийт нэр дэвшигчийг, энэ хуулийн 29.7-д заасныг зөрчсөн бол тухайн нэр дэвшигчийг.” бүртгэхээс татгалзах тухай 33.1.10 дахь заалтыг тус тус нэмсэн.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуульд 19 нам, 2 эвслээс сонгуулийн тойрогт 927, жагсаалтаар 372, бие дааж 42 нэр дэвшигч бүртгүүлсэн бөгөөд дээр дурдсан зорилгын дагуу Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн үр дүнд нийт нэр дэвшигчдийн 61.3 хувь буюу 821 эрэгтэй, 520 буюу 38.7 хувь нь эмэгтэй нэр дэвшигч байсан. Мөн сонгогдсон нийт Улсын Их Хурлын гишүүдийн 32 буюу 25.4 хувь нь эмэгтэй байгаа нь Монгол Улсын парламентын түүхэн дээд үзүүлэлт төдийгүй Ази тивийн дунджаас өндөр үзүүлэлт бөгөөд дэлхийн 187 орны парламентад эзлэх эмэгтэйчүүдийн дундаж үзүүлэлтийг хангасан байна.

Иймд таны санаачлан боловсруулан Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хувьд дэмжиж байна. Мөн уг зохицуулалтыг бодитоор хэрэгжүүлэх чиглэлээр хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэгт “32.1.10.энэ хуулийн 29.2-т заасан нэр дэвшүүлэх ажиллагааны журам зөрчсөн бол нийт нэр дэвшигчийг.” гэсэн агуулга бүхий 32.1.10 дахь заалтыг нэмэх зохицуулалтыг хуулийн төсөлд тусгуулах саналтай байна.

Хүндэтгэсэн,

ДАРГА Н.МЯГМАР

1526040571